



2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН



МОНОС ХҮНС

Аливаа улс үндэстний тусгаар тогтнолын баталгаа нь оюунлаг, эрүүл, хүчирхэг иргэдтэй байхад оршдог. Тэгвэл Монгол хүний оюуны цар хүрээг дэлхийд тунхаглаж, үндэстнийхээ эрүүл мэндийг сахин хамгаалах эрхэм үйлсийн төлөө 30 жилийн баялаг түүхээ зориулсан Монос Группийн нэгэн хэсэг, залгамж халаа бол **Монос Хүнс ХК** юм.

Монос Хүнс ХК-ийн амин сүнс, амжилтын үндэс нь Монгол эрдэмтдийн олон жилийн судалгааны үр дүнд бүтсэн оюуны охь бүтээлүүд, түүх шастир тэмдэглэгдэн үлдсэн ардын уламжлалт анагаах ухааны нууц, байгаль эхийн бүтээсэн ховор эмийн ургамлын төгс зохицолд оршдог билээ.

Бид 2012 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн энэ бүхний ая дан, жор хужрыг тааруулснаар, Монгол хүний биеийн онцлогт тохирсон, амин дэм, эрдэс бодисоор нэн баялаг, эрүүл органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэглэгчдэдээ зориулж ирлээ.

Монос Хүнс ХК нь дэлхийн шилдэг компаниудын хөгжлийн жишгээр 2019 онд Монголын хөрөнгийн зах зээлд IPO гаргаж, олон нийтийн буюу ХУВЬЦААТ компани болсон түүхтэй. Ингэснээр Монголчууд үндэсний үйлдвэрлэгч компанийнхаа зөвхөн хэрэглэгч нь бус жинхэнэ эзэд нь болсон юм.

Эдүгээ тус компани нь Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн нөхцөл байдлын талаарх судалгаанд дурдагдсан зонхилон тохиолдох өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нэн тустай эрүүл мэндийн хуурай болон шингэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Монос Хүнс ХК-ийн бүтээгдэхүүн бүрийн орц найрлага дахь амин дэм, шимт чанар, ашигт байдлыг эрдэмтэн судлаачдын олон жилийн нөр их хөдөлмөр, судалгаа шинжилгээнд тулгуурлаж бүтээгддэг бөгөөд орчин үеийн шинжлэх ухааны шилдэг инновацийг шингээж өгснөөрөө онцлогтой байдаг.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл мэндийг дэмжсэн хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэн, олон улсын стандартаар **ҮЙЛДВЭРЛЭГЧ, ЭКСПОРТЛОГЧ**, дотоодын зах зээлд **ТЭРГҮҮЛЭГЧ** компани байна.



АЛСЫН ХАРАА

ЭРҮҮЛ мэндийг дэмжсэн **ОРГАНИК** хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээнд хэвшүүлнэ.



ҮНЭТ ЗҮЙЛ

- Эрүүл чанартай Бүтээгдэхүүн
- Эрхэм Хэрэглэгч
- Итгэлтэй Харилцагч
- Ёс зүйтэй Бизнес
- Мэдлэг чадвартай бүтээлч Хамт олон
- Шинэ санал Санаачилга
- Монгол Оюун Сэтгэлгээнд хөрөнгө оруулагч

ТҮҮХЭН ЗАМНАЛ

2012



Монос Фарм ХХК-аас өрх тусгаарлаж, **Монос Хүнс ХХК** албан ёсоор үүсгэн байгуулагдав. Эрүүл мэндийн ус, ундааны цехийг ашиглалтад оруулав.

Шилэн савлагаатай **Цэнээ** эрүүл мэндийн бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.



2013

2014



ODOO ERP /Enterprise Resource Planning/ системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

Монгол Улсад анх удаа **Экос pH8.5** зөөлөн шүлтлэг усыг үйлдвэрлэв.



2015

2016



Монгол Улсад анх удаа **Эко уусдаг цай** үйлдвэрлэж эхлэв.

Чанарын удирдлагын тогтолцоо болох **ISO9001:2015** болон Хүнсний аюулгүй байдлын **НАССР** стандартыг нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.



2017

2018



БНХАУ болон **Япон** улсын зах зээлд бүтээгдэхүүнээ байршуулснаар албан ёсоор экспортын гараагаа эхлүүллээ.

Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO гаргаж нээлттэй Хувьцаат Компани болов
Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо **ISO9001:2015** болон Хүнсний аюулгүй байдлын **НАССР** стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Олон улсын аудитын **SGS** компаниар баталгаажуулж гэрчилгээгээ гардан авав



2019

2020



Хүнсний үйлдвэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоо болох **ISO22000:2018** болон Хүний нөөцийн менежментийн **ISO:30400** стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлэв. Эрүүл Мэндийн Шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, **8** нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Л. ХҮРЭЛБААТАР

Монгол Улсын “Хөдөлмөрийн баатар”,
Академич, Монос Хүнс ХК-ийн
ТУЗ-ийн дарга

Монос Хүнс ХК-ийн эрхэм хүндэт хэрэглэгчид, хамтран ажиллагч түнш байгууллагууд, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид та бүхнийхээ амар амгаланг айлтган мэндчилж байна.

Монос групп нь 1990-ээд оны Монгол Улсын шилжилтийн үеийн хүндхэн цаг үед хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулах, нэн шаардлагатай эм тариаг эх орондоо үйлдвэрлэх зорилгоор гал голомтоо бадраасан түүхтэй.

Тус групп нь Монгол Оюун Сэтгэлгээг дэлхийд таниулах эрхэм зорилгыг өвөртлөн, Монгол Улсын Эм зүйн салбарт 30 гаруй жил манлайлан ажиллахдаа салбартаа хэдийн тэргүүлэгч байр сууринд хүрчээ. Энэ хугацаанд бидний үйл ажиллагаа өргөжин тэлж, Моносоор овоглосон 30 гаруй салбар компани үйл ажиллагаа явуулж байгаагаас эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл борлуулалтын үйл ажиллагааг Монос Хүнс ХК явуулж байна.

Дэлхий нийтэд хүнсний аюулгүйн харанга дэлдэж буй энэ цаг үед Монгол үндэстнийхээ эрүүл мэндийг сахин хамгаалах эрхэм үүрэг, өндөр хариуцлага бидэнд бий.

Энэ үүргээ нэр төртэй биелүүлж буй Монос Хүнс ХК-ийн үйлдвэрлэдэг хүнсний нэмэлт бүтээгдэхүүн нь эрдэмтэн судлаачдын олон жилийн туршилт, судалгааны үр дүнд бүтээгдсэн мэдлэг шингэсэн инновацлаг бүтээгдэхүүн гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Эдүгээ Монос Хүнс ХК-ийн эрүүл мэндийг дэмжигч хуурай болон шингэн хүнсний бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээ болж, үүнийг дагаад үйлдвэрлэл болон борлуулалтын орлого нь жил бүр тогтмол 30-40 хувиар өсөж, салбартаа тэргүүлж байна.

Мөн Монос Хүнс ХК нь компанийн засаглалын шилдэг жишгийг Монгол Улсад тогтоож, 2019 онд олон нийтийн буюу Хувьцаат компани болсон. Ингэснээр тус компанийн засаглал, үйл ажиллагаа, ашиг орлого, санхүүгийн тайлан мэдээ олон нийтэд ил тодоор хүрч, хэрэглэгчидтэйгээ хамтдаа хөгжих боломж бүрдсэн нь нэн сайшаалтай юм.

Мөн дэлхийн техник технологийн хөгжил дэвшил, эрдэмтэн судлаачдын нээлтүүд, эрүүл мэндийн боловсролыг эрхэмлэгч хэрэглэгчдийн маань өдөр тутмын амьдралын зөв хэвшил нь бидний шаргуу ажиллах үндэс болж байна.

Тиймээс бид олон улсын чанар стандартаар баталгаажсан эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг олшруулахын зэрэгцээ хэрэглэгчдийнхээ эрүүл мэндийн боловсролыг хөгжүүлж, амьдралын зөв дадлыг айл өрх, иргэн бүрд төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг билээ.

Ирэх олон жилүүдэд ч бид Монгол хүний саруул оюун санаанд түшиглэсэн, хүн амын эрүүл мэндэд өндөр үр дүн авчрах бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулан, эх орныхоо эдийн засагт хувь нэмрээ оруулан, тогтвортойгоор өсөн дэвжихийн төлөө хичээнгүйлэн ажиллах болно.

Монос Хүнс ХК-ийн бүтээгдэхүүнийг таалан хүртдэг эрхэм хэрэглэгчид, итгэл хүлээлгэн хамтран ажилладаг хувьцаа эзэмшигчдэдээ, амжилтын түүхийг хамтдаа бүтээж буй нийт хамт олныхоо нэрийн өмнөөс чин сэтгэлээсээ талархаж буйгаа илэрхийлье.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



Х.Ананд

ТУЗ-ийн гишүүн
Стратеги, Бизнес хөгжлийн
хорооны дарга
Монос Групп
Гүйцэтгэх захирал



Х.Солонго

ТУЗ-ийн гишүүн
Нэр дэвшүүлэх болон цалин
урамшууллын хорооны дарга
Монос Групп
Үйл ажиллагаа
хариуцсан захирал



Ц.Цэцэгбадам

ТУЗ-ийн гишүүн
Монос Групп
Санхүү эрхэлсэн захирал



А.Отгондарь

ТУЗ-ийн гишүүн
Монос Хүнс
Гүйцэтгэх захирал



Ч.Баттогтох

ТУЗ-ийн гишүүн
АШУҮИС
Тэнхимийн эрхлэгч
Доктор, Дэд профессор

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Б.Гантулга

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга
Ард Лайф
Гүйцэтгэх захирал



Н.Долгормаа

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Бодь интернэйшл
Санхүү хариуцсан дэд захирал



Ч.Чинзориг

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Тандем Глобал
Ложистик Монголиа
Гүйцэтгэх захирал

МОНОС ХҮНС ХК-ИЙН ҮЙЛДВЭРҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

Монос Хүнс ХК нь олон улсын чанарын стандарт шаардлагыг хангасан **ЦАЙ, ҮРЛЭН ЧИХЭР, УРГАМАЛ БОЛОВСРУУЛАХ** цехүүдээс бүрдэх Хуурай хүнсний болон **УС УНДАА, БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ** цехүүдээс бүрдэх Шингэн хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг.

ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР



Хүнсний үйлдвэрт **PET** буюу хуванцар, **SHOT** буюу хуруу шилэн, **POUCH** буюу уутан савлагаатай эрүүл мэндийн ус ундаа, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн, зах зээлд нийлүүлж байна.



ХУУРАЙ ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР



ЦАЙ 12,000 ЦАГТ ШИРХЭГ



ҮРЭЛ 12,000 ЦАГТ ШИРХЭГ

Хуурай хүнсний үйлдвэрт байгалийн зэрлэг жимстэй **ҮРЛЭН ЧИХЭР, ОРГАНИК УРГАМЛЫН ЦАЙ, ЖИМСТЭЙ УУСДАГ ЦАЙ** зэрэг бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг.

Бид үйлдвэртээ GMP стандарт буюу үйлдвэрлэлийн зохистой дадлыг мөрдлөг болгон ажилладаг тул бүтээгдэхүүний орц, гарцын урсгал оновчтой төлөвлөгдсөн юм. Мөн ажилчдын хөдөлмөр хамгаалал болон хүнсний аюулгүй байдал бүрэн хангагдсан нөхцөлд эрүүл, чанартай бүтээгдэхүүний маань үйлдвэрлэл тасралтгүй үргэлжилдэг.

ХАМТЫН ХҮЧЭЭР АВЧИРСАН АМЖИЛТ

Монос Хүнс ХК нь **4900** гаруй хөрөнгө оруулагчдынхаа хамтаар нэг жил хүрэхгүй хугацаанд олон улсын стандартад нийцсэн салбартаа жишиг болохуйц Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, үр өгөөжийг нь хүртэж эхлээд байна.

53

Шинээр 53 ажлын байрыг бий болгов



24
ДАХИН

РЕТ шугам үйлдвэрлэлийн хүчин чадлыг 24 дахин нэмэгдүүлэв

6.3
ДАХИН

Экос эрүүл амьдралын усны борлуулалт 6,3 дахин нэмэгдэв

ЭКОС
ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН
УС



30%
БУУРАВ

Нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах цахилгааны хэрэглээ 30 хувиар буурав



Үйлдвэрлэлээс гарсан саарал усыг ахуйн хэрэглээндээ ашиглах боломжтой болов




32% ↑

Компанийн борлуулалтын орлого 32%-аар өсөв

ЗАХ ЗЭЭЛД ШИНЭЭР ГАРГАСАН БОЛОН ШИНЭЧИЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Хувьцаат компани болсон цагаасаа **хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчид, хэрэглэгдийнхээ** өмнө өгсөн амлалтаа алхам алхмаар биелүүлж эхлээд байна.

Үүний нэг жишээ нь шинээр 8 нэр брэндийн бүтээгдэхүүнийг 2020 онд зах зээлд нэвтрүүлэв.



SPARKLING



ISOTONIC



Тун угахзүй

Экос усны савлагааг шинэчлэн нэр төрлийг нэмэгдүүлж зах зээлд дахин байршуулав. Ингэснээр тус бүтээгдэхүүний борлуулалт өмнөх онтой харьцуулахад **6.3** дахин өсөлт үзүүлсэн. Шинээр **Экос зөөлөн оргилуун** усыг зах зээлд нэвтрүүлсэн төдийгүй эрдэс нөхөгч усны технологи хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна.

VITOS
more health

ЦЭНЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ЦЭНЭГЛЭГЧ



Биологийн идэвхт эмийн ургамал, амин дэмийн агууламж өндөртэй жимснүүдийн тааламжит амтыг хослуулсан Монголын анхны эрүүл мэндийн Цэнэг бэлдмэл өнгө төрхөө шинэчлэн Vitos ЦЭНЭГ нэрийн дор үйлдвэрлэгдэж худалдаалагдаж эхэлсэн.

Бөглөөтэй уутан /Spout Pouch/ савлагаанд шилжсэнээр хэрэглэхэд илүү хялбар болсонгоос гадна нэгж савлагааны хэмжээг 100мл болж нэмэгдсэн. Vitos – ЦЭНЭГ эрүүл мэндийн бэлдмэл нь дотоодын зах зээлийн 30 гаруй хувийг 2020 оны байдлаар эзэлж байна.

УВДИСТ БИЕИЙГ ХОРГҮЙЖҮҮЛЭХ УВДИС



Монголын уламжлалт анагаах ухааны судар бичигт хүний биеийг хоргүйжүүлэх чадварыг шагшин тэмдэглэсэн гайхамшигт ургамал хунчир болон хар саримсыг хандлан Увдист эрүүл мэндийн бэлдмэлийг бүтээсэн бөгөөд эдгээр нь дархлаа дэмжих, тамир сэргээх өндөр үр дүнтэй. Ялангуяа хортой нөхцөлд ажиллаж, амьдарч буй хүний биеийн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг дэмжих, эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлдэг.

ТАСАРХАЙ АМТААР СЭРГЭЭГЧ

Монголын анхны цор ганц уусдаг Эко цай зах зээлд нэвтрүүлж байсан туршлага дээрээ үндэслэн зөгийн бал, нимбэг, турмерик, цагаан гаатай Tastea уусдаг цайг бүтээлээ. Энэхүү цай нь хүйтэн сэрүүний улиралд идэвхждэг ханиад томуу зэрэг улирлаас шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, дархлаа дэмжих үйлчилгээтэй, сайхан амт нь сэтгэл сэргээх онцгой чадвартай юм.



ААМИ & ТААМИ

Аами, Таами байгалийн цэвэр жимсний ундаа нь хүүхдэд багачуудад сахарын агууламж өндөртэй бүтээгдэхүүнээс татгалзахад туслах зорилгоор бүтээгдсэн.

ДЭМБ-ийн зөвлөмжид заасан эрүүл хүүхдийн хоногт авбал зохих витамин С-ийн тунг агуулдаг учир Монголын ирээдүй болсон хүүхэд багачуудын дархлааг бүрэн дэмжиж, ханиад томуу тусахаас урьдчилан сэргийлнэ.





БАГАЧУУДЫН ЭРҮҮЛ ЗУГААТАЙ ХЭРЭГЛЭЭ

Монгол орны үржил шимт хөрсөнд ургадаг байгалийн зэрлэг жимс болох Аньс, Нэрс, Чацаргана жимсэнд агуулагдах олон төрлийн аминдэм, эрдэс бодисуудыг хүүхэд багачуудад хүргэх зорилготойгоор BERRYVIT брэндийн Витаминт үрлийг үйлдвэрлэж байна.



Хүүхдийн сонирхлыг татахуйц, зугацуулж тоглуулах боломжтой эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй тоглоомтой BERRYVIT аарцан болон үзэмтэй үрлийг шинээр зах зээлд нэвтрүүлсэн.



БЯЦХАН ҮРСИЙГ ЧИХРИЙН МАНГАСААС ХАМГААЛАХ ЭРЭЛХЭГ БААТАР

Уламжлалт цагаан идээг орчин үеийн технологитой хослуулан Тугал нэртэй шахмал ааруулыг хүүхдийн чихрийн хэрэглээг бууруулах, эрүүл мэндийг дэмжих зорилгоор бүтээв. Аньс, нэрс, чацаргана жимсийг ашиглан бүтээсэн ТУГАЛ шахмал ааруул нь А, В, С аминдэм, уураг, кальциар нэн баялаг тул хүүхдийн өсөлт хөгжилт, яс шүдний бэхжилтийг дэмждэг.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАЙ

Уламжлагдан ирсэн эмийн ургамлын орчин үеийн судалгаа шинжилгээ, онол арга зүйд үндэслэн, анагаах чадвар, биологийн идэвхт чанараараа үл орлогдох нэгдлүүдийг дээжилсэн бүтээл бол “Энхжин” эрүүл мэндийн цуврал цай юм.



Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжих зорилгоор Монголын уламжлалт анагаах ухааны арвин туршлага дээр үндэслэн “Энхжин” цайг анх үйлдвэрлэж эхэлсэн. Энэхүү цайндаа орсон ургамал тус бүрийг биологийн идэвхт бодисын агууламж хамгийн өндөр үед түүж бэлтгэн, тусгай технологиор боловсруулдаг.

Л. Хүрэлбаатар /Зохион бүтээгч/



АЯГАНД УРГАСАН ЖИМС

Байгалийн зэрлэг жимс, цайны ханд бүхий энэхүү цай нь ямар нэгэн хиймэл амт үнэр оруулагч бодисгүйгээр тусгай технологийн дагуу бэлтгэгдсэн Монголын анхны уусдаг цай юм.



Сулийн гурил, хужир, арвай, шар будаа зэргээр хийцэлсэн Эко Өг сүүтэй цайг уламжлалт сүүтэй цайны амт чанарт нийцүүлэн бүтээлээ.

100% ЧАЦАРГАНЫН *Цэвэр тос*

Чацаргана жимсний үр хальсны хандалмал тосыг Монгол орны үржил шимт хөрсөнд тарьж ургуулсан чацаргана жимснээс гаргаж авдаг бөгөөд **С, А, К, Е, В1, В2, Р** амин дэмүүд, **Ω3, Ω6, Ω7, Ω9** омега зэрэг тосны хүчлүүдийг агуулдаг.

Чацарганы тосыг ууж хэрэглэх нь арьсны тослогийг бууруулж, хөнгөн хэлбэрийн батгашилтыг эдгээхэд үр дүнтэй.

Чацарганы тосыг батганд хэрэглэж эмчилгээний үр дүнг тооцох судалгаа "АШУУИС-ийн Арьс Судлалын тэнхим Арьс судлаач клуб 2017 он



Чацарганын ҮР ХАЛЬСНЫ *хандалмал тос*

Тусгай технологиор боловсруулан гаргаж авсан чацарганын тос нь ходоод гэдэсний өвчлөлийг анагаах, шархны эдгэрэлтийг түргэсгэх, эд эсийн нөхөн төлжилтийг сайжруулах, цусан дахь холестерин болон липидийн хэмжээг багасгах, витаминь дутагдлаас сэргийлэх, дархлааг дэмжих нөлөөг үзүүлэх бөгөөд **С, А, К, Е, В1, В2, Р** амин дэмүүд, **Ω3, Ω6, Ω7, Ω9** омега зэрэг тосны хүчлүүдийг агуулдаг.



БАРАГШУН *өйтөрүүдсэн*

Уламжлалт анагаах ухаанд **3,000** жилийн өмнөөс хэрэглэж ирсэн, **400** гаруй өвчин эмгэгийг анагаах, урьдчилан сэргийлэх увдистай байгалийн барагшуныг ариутган хэрэглэхэд хялбар байдлаар үйлдвэрлэв.

Энгийн саримсыг ямар нэгэн химийн бодис холилгүйгээр тусгай исгэх зууханд **30** хоног исгэснээр энгийн саримсны өөх, тос, уураг, магни цайр натри зэрэг химийн элементүүдийг **30** дахин, хөгшрөлийн эсрэг үйлчилгээг **20** дахин нэмэгдүүлсэн. Антиоксидант үйлчилгээтэй учир эд эсийг нөхөн сэргээх бие махбодын эрдэс бодисын хэрэгцээг хангах үйлчилгээтэй.

Шидэт • саримс •



НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ

Бид Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд ёс зүйтэй бизнес эрхлэхийг зорьдог. Мөн хэрэглэгчиддээ эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг хүргэхээс гадна тэдний эрүүл мэндийн боловсролд хувь нэмэр болохуйц сургалт зөвлөгөөг тогтмол өгдөг. 2020 онд дэлхий нийтээрээ хүндхэн сорилттой тулгараад байгаа энэ цаг мөчид ард иргэдэд тулгараад буй асуудалд чиглэсэн дараах ажлуудыг зохион байгууллаа.



ХҮҮХЭД БҮР ЭРҮҮЛ, ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ ИНЭЭМСЭГЛЭЖ БАЙГ

Нийслэлийн гэр хорооллын хүнд нөхцөлд амьдардаг хүүхдүүдэд хоол хүнс хүргэх Лантуун Хүүгийн Богц аянд "Монос Хүнс" ХК өөрсдийн үйлдвэрлэдэг хүүхдийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнээрээ нэгдсэн юм.

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ АЯЛАГЧ

2020 онд нийслэлийн Аялал жуулчлалын газраас дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, эх орныхоо соёлын өв уламжлал бүхий түүхэн дурсгалт газруудаар аялах, иргэд болон аж ахуйн нэгж байгууллагуудын хариуцлагатай, байгальд ээлтэй, хог хаягдалгүй аяллыг дэмжих зорилгоор аялалд гарах гэж буй хэрэглэгчдийг автомашины хогны уутаар урамшуулав.



ГАЛЫН ШУГАМД АЖИЛЛАЖ БУЙ БААТРУУДАА ДЭМЖИВ

Тусгаарлагдсан иргэд, онцгой нөхцөл байдалд өргөсөн тангарагтаа үнэнчээр ажиллаж буй эмч сувилагч, онцгой байдлын албан хаагчдад өөрсдийн үйлдвэрлэдэг дархлаа дэмжих бүтээгдэхүүнүүдээр хандив өгөв. Мөн манай компанийн ажилтнууд урмын үгээ гараар бичин бүтээгдэхүүнийхээ хамтаар хүргүүлсэн билээ. Энэхүү хандивын үйл ажиллагаанд Монос группийн компаниуд нэгдэж нийт 60 сая төгрөгийн үнийн дүнтэй бүтээгдэхүүнийг хандивласан юм.





MONOS CARE АЯН

Тодорхой хугацаанд хэрэглээд хэрэгцээгүй болдог суга таягийг хэрэг болсон хүнд нь хүргэх үүднээс ГССҮТ-өөр эмчлүүлж буй ард иргэдэд үнэ төлбөргүй тараах аяныг хэрэгжүүлсэн.

Аяны хүрээнд хувь хүн, албан байгууллага сайн дурын үндсэн дээр 4,5 сая төгрөгтэй тэнцэх 164 суга таягийг хандивлаж гэмтэж бэртсэн 91 хүнд тус хүргэсэн.



Элэг нэгт хүмүүсээ хүлээн авав

Тусгай үүргийн онгоцоор Ухань хотоос эх орондоо ирсэн 31 оюутан, Монголын улсын бяцхан нэг иргэнд хандив өгөх үйл ажиллагааг санаачлан эхлүүллээ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЦУВРАЛ

Цар тахлын үед хүн бүр эрүүл мэнддээ илүүтэй анхаарах нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, дархлаагаа хэрхэн дэмжих талаар олон талын мэдээ, мэдээлэл багтаасан цуврал видео контентуудыг бэлтгэн хүргэв.

АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЦГЭЭ

Цус Сэлгэлт Судлалын Үндэсний Төвтэй хамтран жил бүрийн 10 дугаар сард цус бэлэглэх өдөрлөгийг зохион байгуулдаг. Энэ жилийн Цусаа бэлэглэх өдөр аяныг дэмжин оролцлоо.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



4,900 гаруй хувьцаа эзэмшигчдийн хамтаар олон улсын GMP стандартын 1772 м2 Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулав.

Тус үйлдвэр нь хамгийн сүүлийн үеийн техник тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бүрэн автомат гэдгээрээ онцлогтой.



Эрүүл Мэндийн Шингэн Хүнсний үйлдвэр ашиглалтад орж “Экос” зөөлөн усны үйлдвэрлэлийн хүчин чадал **24 гахун** нэмэгдэв.



**1 Сая Ширхэг
Үйлдвэрлэв**

ISO22000 БОЛОН ISO30400 СТАНДАРТУУДЫГ НЭВТРҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ



ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо стандартыг Шингэн хүнсний үйлдвэрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилгоор төслийн багийг байгуулж үйл ажиллагааг эхлүүлэв.



Хүний нөөцийн ISO:30400 багц стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.



“I” АНГИЛЛЫН ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОО

Монос Хүнс ХК 2019 оны 5-р сард олон нийтэд хувьцаагаа арилжаалж эхэлсэн бөгөөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд компанийн үйл ажиллагаа, ашиг орлого өсөн нэмэгдэж, хувьцаат компанийн засаглалын зарчмыг мөрдөн ажилласнаар “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хувьцааны бүртгэлийн II ангиллаас дэвшин I ангилалд бүртгэгдлээ.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛАА ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАВ

Монос Хүнс ХК 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаа амжилттайгаар зохион байгууллаа. Энэ удаагийн хурал дэлхий дахинд үүсээд буй Ковид-19 вирусийн тархалттай холбоотойгоор цахим хэлбэрээр хийгдсэн бөгөөд хурлын үеэр “Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр”-тэй виртуал аялал хийх боломж олгосноороо онцлогтой боллоо.



КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРГӨЖСӨӨР БАЙНА

Шинэ төрлийн COVID-19 вирусийн тархалтын үед ажлын байрны цомхотгол хийгээгүй бөгөөд ажлын байрны орон тоо өмнөх оны мөн үеийнхээс 36%-аар өслөө.

36%▲



АНУ-ЫН FDA БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛЭЭ

АНУ-ын Эрүүл мэндийн яамны харьяа FDA буюу Food and drug administration байгууллага Монос Хүнс ХК-ийг Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэгч хэмээн бүртгэсэн бөгөөд ингэснээр АНУ-д албан ёсоор экспорт хийх үүд хаалга нээгдэв.



АНУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ НЭВТРҮҮЛЭВ

Монгол орны үржил шимт хөрсөнд ургасан чацаргана жимсийг тусгай технологиор боловсруулан бүтээсэн чацаргана жимсний 100 хувийн цэвэр тос дэлхийн хамгийн том цахим дэлгүүр Amazon.mn сайт дээр байршин худалдаалагдаж эхэллээ.

available at
amazon



RETREAT 2020

Монос Хүнс ХК нь ирэх жилийнхээ бизнес стратеги төлөвлөгөөг илүү бодитой гаргах, SWOT анализыг илүү зөв, орчин үеийн байдлаар гаргах зорилготой Retreat арга хэмжээг "Marabunta" нэрийн дор хоёр өдрийн турш амжилттай зохион байгуулагдлаа.



ХЭТИЙН ЗОРИЛГО

Дэлхийн хэмжээнд тухайн компанийн засаглал, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны чанарыг нь тодорхойлохдоо олон улсад даган мөрддөг холбогдох стандартуудаар хэмждэг.

Энэ нь тухайн компани нь хэр найдвартай, чанартай, баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэж буйг нотлох гол шалгуур болдог юм.

Монос Хүнс ХК-ийн хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ шат дамжлага бүрт олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо болох ISO 9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартыг нэвтрүүлсэн бөгөөд өдөр бүр баталгаажуулалт хийн ажиллаж байна.

Ингэснээр ажлын байран дахь ажилтнуудын хариуцлага нэмэгдэж, үйлдвэрлэлийн доголдол үүсэх эрсдэл бүрэн хаагдаж, бүтээгдэхүүний чанар дээд зэргээр хамгаалагдсан юм.



Цаашид компанийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Хүний нөөцийн менежментийн ISO 30400 болон Хүнсний Аюулгүй Байдлын Удирдлагын ISO 22000, Үйлдвэрлэлийн зохистой дадал GMP зэрэг олон улсын удирдлагын тогтолцооны стандартуудыг шат дараатайгаар нэвтрүүлэхээр зорьж байна.

Мөн компанийн жилийн борлуулалтыг дунджаар 20 хувь, цэвэр ашгийн төвшинг дунджаар 13 хувиар тогтмол өсгөн, борлуулалтын орлогын 10 хувийг экспортоос бүрдүүлэх зорилтыг өмнөө тавин ажиллаж байна.

Монос Хүнс ХК нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ дамжуулан хэрэглэгчдийнхээ эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зөв дадлыг амьдралдаа хэвшүүлэхэд нь туслахыг онцгойлон анхаарч байна.

Хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд ховор төрлийн эмийн ургамал, сүү цагаан идээгээр баяжуулсан хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг тогтмол хэрэглэх нь өндөр үр дүн үзүүлдэг.

Тиймээс эрдэмтдийн судалгаанд үндэслэсэн, эрч хүчийг бэлэглэж, эрүүл мэндийг хамгаалах хүчирхэг найрлага бүхий шинэ брэндийг бүтээн, зах зээлд нэвтрүүлэхийн төлөө бид цаг ямагт хичээнгүйлэн ажилладаг билээ.

Монос Хүнс ХК нь Монголын эрүүл мэндийг дэмжигч хүнсний бүтээгдэхүүнийн зах зээлд тэргүүлэгч байр сууриа бататгаж, дэлхийн тавцанд хүчтэй өрсөлдөгч болохоо нотлон харуулахаар зорьж байна



ХУВЬЦААНЫ ХАНШИЙН МЭДЭЭЛЭЛ

Монос Хүнс ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар **27.4** тэрбум төгрөг байна. Жилийн арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв:


Хамгийн дээд ханш **75.00**

Хамгийн доод ханш **59.86**


Арилжааны ширхэг **6,965,278**

Арилжааны үнийн дүн **475,245,661**

Хувьцааны арилжаа



Ноогдол ашиг хуваарилалт



Монос хүнс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн №34/02 тоот тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1 төгрөг буюу нийт **408** сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн бөгөөд энэ нь нийт цэвэр ашгийн **40.5** хувьтай тэнцэж байна.

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт /мянган төгрөг/	2019.12.31	2020.12.31
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,999,343	19,241,571
Эргэлтийн хөрөнгө	5,040,000	5,623,617
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,056,219	58,125
Дансны авлага	1,732,148	2,556,793
Татвар, НДШ – ийн авлага	7,679	38,306
Бусад авлага	59,462	35,813
Бараа материал	1,600,457	2,466,268
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	584,034	468,313
Эргэлтийн бус хөрөнгө	15,959,343	13,617,954
Үндсэн хөрөнгө	13,931,689	13,091,043
Биет бус хөрөнгө	1,990,521	438,095
Хойшлогдсон татварын хөрөнгө	37,133	41,016
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	47,800
НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН ДҮН	20,999,343	19,241,571
Богино хугацаат өр төлбөр	1,718,248	5,929,757
Дансны өглөг	510,469	664,411
Цалингийн өглөг	42,268	57,508
Татварын өр	318,066	553,856
НДШ - ийн өглөг	5,674	39,142
Богино хугацаат зээл	-	4,114,346
Хүүний өглөг	376,270	78,452
Урьдчилж орсон орлого	4,174	5,415
Нөөц /өр төлбөр/	-	39,264
Бусад богино хугацаат өр төлбөр	461,328	377,363
Богино хугацаат өр төлбөрийн дүн	456,051	4,490,273
Урт хугацаат өр төлбөр	3,400,232	11,670
Урт хугацаат зээл	3,334,346	-
Бусад урт хугацаат өр төлбөр	65,886	11,670
Эздийн өмч	15,880,863	13,300,144
Энгийн хувьцаа	2,318,182	2,318,182
Нэмж төлөгдсөн капитал	6,835,733	6,835,733
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,102,125	616,144
Хуримтлагдсан ашиг	2,624,823	3,530,086
Эздийн өмчийн дүн	15,880,863	13,300,144

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

Үзүүлэлт /мянган төгрөг/	2019.12.31	2020.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	9,433,040	12,491,129
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	5,204,353	6,932,564
Нийт ашиг (алдагдал)	4,228,688	5,558,565
Түрээсийн орлого	5,917	2,403
Хүүний орлого	223,906	3,407
Бусад орлого	7,577	218,279
Борлуулалт, маркетингийн зардал	2,179,453	2,803,081
Зардал	1,037,926	1,191,040
Санхүүгийн зардал	252,736	321,628
Бусад зардал	107,125	137,190
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-20,231	-36,241
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-123,136
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	0
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	868,616	1,170,339
Орлогын татварын зардал	106,673	160,110
Тайлант үеийн цэвэр ашиг (Алдагдал)	761,943	1,010,229



+976 77773525



foods@monos.mn
www.monosfoods.mn



Чингисийн өргөн чөлөө 205/2, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17043, Монгол Улс